



Q-U (QUESTIONNAIRE–UTILITIES) АРГАЧЛАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ДАВУУ ТАЛ БА МОНГОЛ УЛСАД НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ

Н.Оюунтунгалаг^а, Г.Бямбагтох^б
^аМУБИС-Багшийн сургууль, багш;
^бМУБИС-Багшийн сургууль, багш

Холбоо барих зохиогч: Byambatogtokh@msue.edu.mn

Хүлээн авсан: 2025.08.30

Хянагдсан: 2025.09.30

Зөвшөөрсөн: 2025.10.30

Хураангуй

1990-ээд оноос хойш Японы боловсролын байгууллагууд сурагчдын нэрийг ил тод бичүүлэх, бусдын талаарх хувийн үнэлгээг гаргах явц нь хүүхдийн нэр төр, хувийн нууц, сэтгэлзүйн аюулгүй байдлыг зөрчих эрсдэлтэй гэж үзэх хандлага өргөн дэлгэрчээ. Энэ нь сургалтын орчин дахь ёс зүйн асуудалд анхаарал хандуулах шаардлагыг нэмэгдүүлж, сурагчдын харилцаа, анги хамт олны уур амьсгалыг судлах уламжлалт социометрийн аргыг хэрэглэх нь буурсан байна. Үүний оронд сурагчдын сэтгэлзүй, нийгмийн дасан зохицлыг үнэлэхэд илүү нууцлалтай, найдвартай, ёс зүйн шаардлагад нийцсэн хэмжилзүйн арга хэрэгсэл нэвтрүүлэх хэрэгцээ бий болсон юм. Энэ нөхцөлд Японд боловсруулагдсан Q-U (Questionnaire–Utilities) аргачлал нь сурагч бүрийн нэрийг нууцлан, анги доторх сэтгэлзүйн уур амьсгал, харилцааны уялдаа холбоог асуумжийн хэлбэрээр үнэлэх шинэ боломжийг бүрдүүлжээ. Тус арга нь сурагчдын сургалт болон хамт олондоо дасан зохицох түвшин, сэтгэл ханамжийг тоон үзүүлэлтээр илэрхийлэх бөгөөд сургалтын орчныг сайжруулахад бодит мэдээлэл өгөх ач холбогдолтой юм. Q-U аргачлалын хэрэглээ нь орчин үеийн боловсрол дахь сэтгэлзүйн хэмжилзүйн ёс зүйн соёл, хүүхдийн эрхийн хамгаалалт, нийгэм-сэтгэлзүйн аюулгүй байдлыг хангах шинэ чиг хандлагыг төлөөлж байна.

Түлхүүр үг

сэтгэлзүйн хэмжилзүй, анги хамт олны уур амьсгал, дасан зохицол, сургалтын орчин, ёс зүй, нууцлал
Q-U аргачлал

Удиртгал

Анги хамт олны уур амьсгал нь сурагчдын нийгэмших үйл явц, сэтгэлзүйн сайн сайхан байдал, сурах идэвх, хандлагад чухал нөлөө үзүүлдэг. Сэтгэлзүйн хувьд тогтвортой, итгэлтэй орчинд суралцаж буй хүүхдүүд сургалтын үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцож, бусадтай үр дүнтэй хамтран ажиллахын зэрэгцээ нийгмийн харилцааны ур чадвараа хөгжүүлэх хандлагатай байдаг (Kawamura, 2006). Иймд анги хамт олны уур амьсгалыг системтэй үнэлэх, сурагчдын харилцааны онцлог ба дасан зохицлын түвшинг тодорхойлох нь зөвхөн боловсролын чанарыг дээшлүүлэх төдийгүй, сэтгэлзүйн дэмжлэг шаардлагатай суралцагчдыг эрт илрүүлж, тэдэнд чиглэсэн зөвлөгөө, туслалцааг үр дүнтэй төлөвлөхөд чухал ач холбогдолтой юм.

Анги хамт олны уур амьсгалыг судлахад сэтгэл судлал, боловсрол судлалын олон төрлийн арга хэрэглэгддэг бөгөөд ажиглалт, ярилцлага, асуумжийн арга зэрэг чанарын болон тоон судалгааны аргуудыг хослуулсан судалгаанууд түгээмэл байдаг. Эдгээрийн дотроос бүлгийн дотоод харилцааг илрүүлэх, анги доторх нийгмийн бүтцийг шинжлэх зорилготой социометрийн судалгаа (sociometry) нь онолын хувьд ч, практик хэрэглээний хувьд ч үнэ цэнтэй арга юм.

Социометрийн аргыг Америкийн сэтгэл судлаач Jacob L. Moreno (1892–1976) анх боловсруулсан бөгөөд энэхүү арга нь бүлгийн гишүүдийн хоорондын харилцан сонголт болон таггалзлын хандлагыг тодорхойлж, тэдгээрийг график хэлбэрээр (социограмм) дүрслэн бүлгийн дотоод бүтцийг илрүүлэхэд чиглэдэг (Moreno, 1951). Энэ нь сурагчдын найз нөхдийн сүлжээ, хамт олны харилцааны хэв маягийг тодорхойлох, ганцаардсан хүүхдийг илрүүлэхэд үр дүнтэй хэрэглэгдэж ирсэн.

Q-U аргачлалын тухай

Сургуулийн орчинд сурагчдын дасан зохицол, хамт олны уур амьсгалыг хэмжих олон төрлийн сэтгэлзүйн үнэлгээний аргачлалын дотроос Японд боловсруулагдсан Q-U (Questionnaire–Utilities) арга нь нэр нууцлал, хэмжилзүйн найдвартай байдал, боловсролын бодлогод суурилсан хэрэглээгээрээ онцлог юм. Энэхүү аргачлалыг Васэда их сургуулийн профессор Шигэо Кавамура (Shigeo Kawamura) болон түүний хамтран ажиллагчид боловсруулсан бөгөөд 30,000 гаруй сурагчийн өгөгдөлд тулгуурлан боловсруулсан стандартчилсан, баталгаатай, найдвартай сэтгэлзүйн үнэлгээний хэрэгсэл юм.

Q-U нь өнөөдөр Японы бага, дунд, ахлах сургуулиудад өргөн хэрэглэгдэж байна (Kawamura, 2006). Q-U арга нь сурагчийн сургуулийн амьдрал дахь сэтгэл ханамж, анги хамт олны уур амьсгал, сургалт дахь оролцоо, идэвхийг асуумжийн хэлбэрээр хэмжиж, тэдгээрийг сэтгэлзүйн дасан зохицлын тоон үзүүлэлтээр илэрхийлдэг. Энэ нь анги доторх уур амьсгалыг бодитоор тодорхойлох, дотоод харилцааны онцлогийг илрүүлэх, сурагчдын “сургуулийн амьдралд дасан зохицох чадвар”-ыг үнэлэхэд чиглэдэг (Hogikuchi, 2016). Мөн Q-U аргачлал нь сурагчийн анги доторх уур амьсгал, багш болон найз нөхөдтэй харилцах харилцаа, сургуулийн амьдралд оролцох идэвхийг тоон өгөгдлөөр үнэлэх боломж олгодог бөгөөд багшийн субъектив ажиглалтад суурилсан уламжлалт үнэлгээг бодитоор нөхөх үүрэгтэй (Kuroda, 2015).

Q-U аргачлалын үндсэн зорилго нь:

- Сургуулийн амьдрал дахь сурагчийн дасан зохицол, оролцоог үнэлэх;
- Хичээл таслах болон сургуулиас завсардах эрсдэлээс урьдчилан сэргийлэх;
- Үе тэнгийн дээрэлхэл, гадуурхалтын шинж тэмдгийг эрт илрүүлэх;
- Тусгай дэмжлэг шаардлагатай сурагчдыг тодорхойлох;
- Багш, сэтгэлзүйч, анги удирдсан багшийн менежментийн шийдвэрт өгөгдөлд суурилсан дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Хамрах хүрээ: бага, дунд, ахлах ангийн сурагчид.

Давтамж: Жилд хэд хэдэн удаа хэрэгжүүлснээр сурагчдын сэтгэлзүйн өөрчлөлт, дасан зохицлын динамикийг урт хугацаанд хянах боломжтой. Ингэснээр Q-U нь нэг удаагийн судалгаа бус, суралцагчийн сэтгэлзүйн төлөв байдлын өөрчлөлтийг системтэйгээр ажиглах хяналтын хэрэгсэл болдог.

Q-U аргачлал нь дараах хоёр үндсэн асуумж дээр тулгуурладаг:

1. “Идэвхтэй орчин бүрдүүлэх асуумж” (School Life Motivation Scale). Энэ хэсэг нь сурагчийн сургалт болон сургуулийн амьдралд оролцох идэвх, хамт олонтой харилцах хандлагыг үнэлдэг.
 - Найз нөхдийн харилцаа (1–3 асуулт)
 - Суралцах сонирхол, хичээлд оролцох байдал (4–6 асуулт)
 - Ангийн үйл ажиллагаанд оролцох идэвх (7–9 асуулт)
- Сургуулийн орчин дахь сурагчийн идэвх, сэтгэлзүйн дасан зохицлын түвшинг илрүүлэх зорилготой.
2. “Таатай уур амьсгал бүрдүүлэх асуумж” (Classroom Satisfaction Scale) Энэ хэсэг нь сурагчийн анги доторх сэтгэл ханамж, хүлээн зөвшөөрөгдөж буй мэдрэмж болон гадуурхагдаж буй мэдрэмжийг хэмждэг.
 - Хүлээн зөвшөөрөгдөж буй мэдрэмжийн оноо (1–6 асуулт)
 - Гадуурхагдаж буй мэдрэмжийн оноо (7–12 асуулт)

Онооны үнэлгээ ба ангиллын загвар

Q-U аргачлалын үнэлгээ нь хоёр тэнхлэгийн дагуу хийгддэг:

- Хэвтээ тэнхлэг — *Гадуурхагдаж буй мэдрэмжийн оноо*
- Босоо тэнхлэг — *Хүлээн зөвшөөрөгдөж буй мэдрэмжийн оноо*


Эдгээрийг уялдуулан сурагчдыг дараах дөрвөн бүлэгт ангилдаг. Үнэлгээг дараах матрицын дагуу дүрсэлдэг (хүснэгт 1).

Хүснэгт-1. Q-U аргачлалын онооны тайлбар

Хүлээн зөвшөөрөгдөх оноо	Гадуурхалтын оноо	Бүлгийн нэршил	Тайлбар
≥ 18	≤ 10	Сэтгэл ханамжтай бүлэг	Найз нөхдийн харилцаа сайн, ангийн уур амьсгал эерэг, идэвх өндөр
< 18	≤ 10	Үл хүлээн зөвшөөрөгдөж буй бүлэг	Идэвх сул, оролцоо бага, бүлгээс хөндий байдал ажиглагдана
≥ 18	> 10	Гадуурхагдсан бүлэг	Харилцааны зөрчил, үл ойлголцол, дарамт мэдрэх байдал илэрдэг
< 18	> 10	Сэтгэл ханамжгүй бүлэг	Эмзэг, сэтгэлзүйн дэмжлэг шаардлагатай сурагчид хамаарна

Судалгааны үр дүнгээс үзэхэд, “сэтгэл ханамжтай” бүлэгт хамаарах сурагчдын сурлагын амжилт, суралцах хандлага илүү өндөр байхад, “сэтгэл ханамжгүй” болон “гадуурхагдсан” бүлгийн сурагчдын сурлагын түвшин доогуур байдаг (Imanishi, 2020). Эдгээр үр дүн нь сурагчийн анги хамт олны уур амьсгалд сэтгэл ханамжтай байх нь түүний танин мэдэхүйн идэвх, өөртөө итгэх итгэл, суралцах хандлага зэрэг сэтгэлзүйн хүчин зүйлстэй нягт уялдаатай болохыг харуулдаг. Иймээс Q-U аргачлал нь зөвхөн анги хамт олны уур амьсгалыг тоон хэлбэрээр үнэлэх хэрэгсэл бус, сурагчийн сэтгэлзүйн дасан зохицол ба сурлагын амжилтын уялдаа холбоог судлахад үр дүнтэй арга зүй юм.

Зураг 1. Q-U аргачлалын үр дүнгийн матриц



Анги хамт олны хэв шинж (Classroom Type Model)

Kawamura (2006)-ийн загварт анги хамт олны уур амьсгалыг дүрэм журам (rule) болон харилцааны холбоо (relationship) гэсэн хоёр тэнхлэгийн дагуу таван хэлбэрт ангилдаг. Онолын хувьд, анги хамт олныг тогтвортой, эерэг уур амьсгалтай байлгахын тулд “дүрэм (rule)” ба “харилцаа (relation)” гэсэн хоёр хүчин зүйл зэрэг тогтсон байх шаардлагатай гэж үздэг (Kawamura, 2006).


- “Дүрэм” гэдэг нь анги доторх харилцаанд хамаарах, хамтран ажиллах болон өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлах нийтлэг ойлголт, хэм хэмжээ юм. Дүрэм сайн тогтсон тохиолдолд харилцааны зөрчил багасаж, сурагчид “аюулгүй, итгэлтэй орчинд” найз нөхөдтэй харилцах, хамтран суралцах боломж бүрддэг.
- “Харилцаа” гэдэг нь сурагчдын хоорондын итгэлцэл, сэтгэл хөдлөлийн солилцоо, хамтын ажиллагаа идэвхтэй өрнөж буй төлөвийг хэлнэ. Харилцаа

сайн хөгжсөн үед хүүхдүүдийн хооронд найрсаг уур амьсгал бүрэлдэж, хамтын үйл ажиллагаа (хичээл, арга хэмжээ, тусгай ажиллагаа гэх мэт) илүү үр дүнтэй болдог.

Q-U-ийн үнэлгээнд “гадуурхагдаж буй мэдрэмж” нь “дүрмийн түвшин”-тэй урвуу хамааралтай байдаг бол, “хүлээн зөвшөөрөгдөх мэдрэмжийн оноо” нь “харилцааны түвшин”-тэй шууд хамааралтай болох нь тогтоогдсон. Өөрөөр хэлбэл, дүрэм сайтар тогтсон ангиудад гадуурхалт, үл ойлголцол багасдаг бол, харилцаа өндөр түвшинд хөгжсөн ангиудад сурагчдын сэтгэл ханамж, итгэлцэл нэмэгддэг (Kawamura, 2006).


1. “Тогтвортой, идэвхтэй анги” – (тархалт баруун дээд хэсэгт төвлөрсөн)

- Дүрэм болон харилцаа аль аль нь сайн тогтсон.
- Сурагчдын “хүлээн зөвшөөрөгдөх мэдрэмж” өндөр, хамтын оролцоо идэвхтэй.
- Хүүхдүүдийн хооронд харилцан итгэлцэл, урам зориг, инээмсэглэл давамгайлсан, багш сурагчийн харилцаа нээлттэй.
- Анги дотор эерэг уур амьсгал бүрэн тогтсон хамгийн “тохиромжтой” хэлбэр юм.




2. Харьцааны ялгаатай анги - (тархалт баруун дээд болон доод хэсэгт төвлөрсөн)

- Дүрэм тогтсон боловч сурагчдын хооронд “хүлээн зөвшөөрөгдөх мэдрэмж”-ийн ялгаа их байна.
- Зарим сурагч илүү идэвхтэй оролцдог бол, зарим нь дотогшоо, хөндий хандлагатай.
- Хүүхдүүдийн хооронд нийгмийн зай барилт ажиглагдаж, анги дотор “нам гүм, хүйтэн” уур амьсгал давамгайлах магадлалтай.
- Энэ хэлбэр нь “дүрмийн хувьд тогтвортой ч, харилцааны хувьд сул” анги юм.




3. “Хэт чөлөөт, дүрэм сул анги” (тархалт баруун зүүн дээд хэсэгт төвлөрсөн)

- Хүүхдүүд эрч хүчтэй, илэн далангүй харилцаатай боловч, дүрэм журам сул, зохион байгуулалт муутай.
- Багшийн удирдлага сул байх үед, сурагчдын хувийн зан авир давамгайлж, жижиг зөрчил үүсэх хандлагатай.
- Анги дотор “эрч хүчтэй боловч эмх замбараагүй” байдал ажиглагддаг.




4. “Тэнцвэр алдагдсан анги” (тархалт налуу суналттай)

- 2 ба 3 хэв шинжийн дундах шилжилтийн хэлбэр.
- Нэг талаас зарим хүүхэд идэвхтэй, найрсаг харилцаатай байхад, нөгөө талаас дүрэм сахих хандлага суларсан.
- Гаднаа тайван харагдавч, дотоод харилцааны уур амьсгал тогтворгүй.
- Энэ хэлбэрийн ангиудад жижиг маргаан, үл ойлголцол нэмэгдэх хандлагатай.



5. “Сэтгэл ханамжгүй, эмзэг анги” (тархалт зүүн доод хэсэгт төвлөрсөн)

- Анги хамт олны 70%-иас дээш нь “сэтгэл ханамжгүй бүлэгт” хамаардаг.
- Дүрэм тогтворгүй, харилцаа суларсан, хамтын орчин бүрдээгүй.
- Хичээл, бүлгийн үйл ажиллагаа амжилтгүй болж, сурагчдын дунд сөрөг хандлага, гадуурхал, үл ойлголцол давамгайлдаг.
- Энэ хэлбэрийн ангиуд нь сэтгэлзүйн дэмжлэг, багшийн менежментийн тусгай анхаарал шаарддаг.



Эдгээр хэв шинж нь анги доторх “сэтгэлзүйн температур”-ыг тоон болон дүрслэх хэлбэрээр илэрхийлж, багш, сэтгэлзүйч нарт ангийн менежмент, сэтгэлзүйн дэмжлэг, үе тэнгийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд үнэтэй мэдээлэл өгдөг.

Судалгааны үр дүн

Монголын нөхцөлд хэрэгжүүлэх боломж: Монголын сургуулиудад анги доторх дасан зохицол, уур амьсгалыг ёс зүйд нийцсэн, найдвартай аргаар хэмжих хэрэгцээ өндөр байна. Q-U (Questionnaire–Utilities) аргачлалыг нутагшуулах нь уламжлалт социометрийг орлох тухай биш, харин нэр нууцлалтай, сэтгэлзүйн дарамт багатай, хэмжилзүйн баталгаатай үнэлгээг сургалтын практикт нэвтрүүлэх альтернатив шийдэл юм.

Одоогоор Q-U аргачлалын бага ангийн хүүхдүүдэд хэрэглэгдэх хувилбарын Монгол хэлний анхан шатны орчуулга боловсруулагдаж, их сургуулийн хичээл дээр туршилтын хэлбэрээр танилцуулагдаад байна. Туршилтын оролцогч оюутнуудын үнэлгээнээс харахад, “Монголын сургуулийн нөхцөлд хэрэглэх бүрэн боломжтой” гэсэн дүгнэлт давамгайлав. Цаашдын нутагшуулах ажлын түлхүүр алхмууд нь жижиг хэмжээний түүвэр судалгаанд туршиж найдвартай байдлын коэффициент (жишээлбэл, Cronbach’s α)-ийг тодорхойлох, орчуулгын утга ба найруулгын эквивалентыг баталгаажуулж соёлын тохируулга хийх, хэмжилзүйн баталгаажуулалт буюу баталгаажсан хүчин зүйн шинжилгээ, огтлолцол-баталгаажуулалтыг гүйцэтгэх зэрэг шат дараатай ажлуудыг хамарна. Ингэснээр

Q-U аргачлал нь Монголын сургалтын орчинд сурагчийн сэтгэлзүйн дэмжлэгийн тогтолцоог бэхжүүлэх, анги хамт олны эерэг уур амьсгалыг төлөвшүүлэх, улмаар сургалтын чанарыг дээшлүүлэх арга зүйн чухал суурь болж чадна.

Дүгнэлт

Ангийн уур амьсгалыг системтэй судалж, тогтмол үнэлэх нь сурагчдын нийгэмших үйл явц, сайн сайхан байдал, сурах идэвхийг дэмжих боловсролын бодлого, сургуулийн сэтгэлзүйн дэмжлэгийн тогтолцооны гол тулгуур юм. Монголд анги доторх дасан зохицол, харилцааны бүтцийг тоон ба чанарын хосолсон аргаар найдвартай үнэлэх хэрэгсэл хомс байгаа нь шинэчлэл шаардлагатайг тод харуулж байна. Японд боловсруулсан Q-U аргачлал нь нэр нууцлалыг ханган, сургуулийн дасан зохицол, сэтгэл ханамж, гадуурхалтын мэдрэмж, харилцааны чанар зэрэг үзүүлэлтийг нэгэн зэрэг хэмжих боломжтой (жиш., Kawamura, 2006; Kuroda, 2015; Imanishi, 2020). Энэ аргачлал нь зөвхөн үнэлгээний хэрэгсэл төдий бус, сурагчдын үе тэнгийн дээрлэхэд, хичээл таслалт болон сургуулиас завсардах зэрэг сөрөг зан үйлийн эрсдэлийг урьдчилан илрүүлэхэд ашиглагддаг бөгөөд, анги доторх сэтгэлзүйн уур амьсгалын мэдээлэлд тулгуурлан багшийн менежментийн шийдвэрийг өгөгдөлд суурилсан байдлаар гаргах боломжийг олгодог менежментийн загвар болж хөгжсөн юм. Q-U аргачлалын Монголын боловсролын орчинд хэрэглэх ач холбогдол гурван түвшинд илэрнэ. Нэгдүгээрт, судалгааны түвшинд анги доторх уур амьсгал, сурагчдын дасан зохицлын талаарх суурь өгөгдлийг бүрдүүлж, урт хугацааны өөрчлөлтийг системтэйгээр хянах, дүн шинжилгээ хийх боломжийг олгоно. Хоёрдугаарт, сургуулийн түвшинд багш, сэтгэлзүйчид сурагчдын сэтгэлзүйн эрсдэлийг эрт илрүүлж, бодит өгөгдөлд тулгуурлан чиглэсэн дэмжлэг үзүүлэх, анги менежментийг илүү оновчтой зохион байгуулах нөхцөл бүрдэнэ. Гуравдугаарт, бодлогын түвшинд сургалтын чанарыг сайжруулах, сурагчийн сайн сайхан байдлыг хамгаалах зорилгоор боловсролын бодлого, хөтөлбөр, журам боловсруулахад ашиглагдах үзүүлэлт, судалгааны индикатор бий болгох ач холбогдолтой.

Иймээс Q-U аргачлал нь Монголын сургалтын орчинд анги хамт олны уур амьсгалыг ёс зүйтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй, системтэйгээр үнэлэх бүрэн боломжтой аргачлал гэж үзэж байна. Энэхүү аргыг нутагшуулах, хэмжилзүйн баталгаажуулалт хийх ажлыг шат дараатай хэрэгжүүлснээр сурагчийн сэтгэлзүйн дэмжлэгийг сайжруулах, анги хамт олны эерэг уур амьсгалыг төлөвшүүлэх, цаашлаад сургалтын чанар болон хүний хөгжлийн бодлогод бодит хувь нэмэр оруулах чухал арга зүйн суурь бүрдэх юм.

Ном зүй

1. 堀口哲男（2016）．『Q-U』と『hyper-Q-U』の紹介 [Introduction of “Q-U” and “hyper-Q-U”]. 教材活用シリーズ, 第94回. 図書文化社 Horikuchi, T. (2016). Introduction of “Q-U” and “hyper-Q-U.” Kyōzai Katsuyō Series, No. 94. Toshobunka Publishing.
2. 河村茂雄（2006）．学級づくりのための Q-U 入門：「楽しい学校生活を送るためのアンケート」活用ガイド 図書文化社. Kawamura, S. (2006). Introduction to Q-U for Classroom Building: A Guide to Using the “Enjoyable School Life Questionnaire.” Toshobunka Publishing.
3. 河村茂雄（2006）．Q-Uによる特別支援教育を充実させる学級経営：さまざまなニーズの子どもが共に育つ学級づくり. 図書文化社. Kawamura, S. (2006). Classroom Management to Enrich Special Support Education through Q-U: Creating a Classroom Where Children with Various Needs Grow Together. Toshobunka Publishing.
4. 黒田一寿（2015）．Q-U を用いた学級集団の分析（その3） [An Analysis of Class Communities by Using Questionnaire-Utilities (Part 3)]. 東京工業高等専門学校研究報告, 第47号. Kuroda, K. (2015). An analysis of class communities by using Questionnaire-Utilities (Part 3). Bulletin of Tokyo National College of Technology, 47.
5. 今西一仁（2020）．Q-U を活用した児童生徒理解 [Understanding Students by Using Q-U]. 高知県心の教育センター. Imanishi, K. (2020). Understanding Students by Using Q-U. Kōchi Prefectural Center for Mental Education.
6. “Sociometry wo Mou Ichido (ソシオメトリーをもう一度)” (n.d.). Documentary Report. Retrieved from <http://www2.chokai.ne.jp/~assoonas/UC331.HTML>:

THE ADVANTAGES OF THE Q-U (QUESTIONNAIRE–UTILITIES) METHOD AND ITS FEASIBILITY FOR IMPLEMENTATION IN MONGOLIA

^aOyuntungalag N., ^bByambatogtokh G.

^aTeachers School, MNUE;

^bTeachers School, MNUE

Corresponding author: Byambatogtokh@msue.edu.mn 

Abstract

Since the 1990s, there has been a growing awareness in Japan’s educational institutions that practices such as making students’ names public and conducting peer evaluations may violate children’s dignity, privacy, and psychological safety. This shift has brought increased attention to ethical issues in the learning environment and led to a decline in the use of traditional sociometric methods for studying classroom relationships and group atmosphere. Consequently, there has emerged a need for more confidential, reliable, and ethically appropriate psychometric tools to assess students’ psychological and social adaptation. In this context, the Q-U (Questionnaire–Utilities) method, developed in Japan, has provided a new approach for anonymously evaluating the psychological climate and interpersonal relationships within classrooms through structured questionnaires. This method allows the quantification of students’ levels of satisfaction and adjustment to school life, offering valuable data for improving the educational environment. The application of the Q-U methodology represents a new trend in educational psychology—one that emphasizes ethical psychometrics, the protection of children’s rights, and the assurance of social and psychological safety within modern educational settings.

Keywords

Psychometrics, classroom climate, adaptation, learning environment, ethics, confidentiality, Q-U method
